



**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ**

УЛААНБААТАР ХОТ
2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр

**“МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ**

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16^{1.5.2} дахь заалтыг үндэслэн Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөл (ТТБЗ) дүгнэлтээ гаргалаа. Зөвлөл дүгнэлт гаргахдаа өргөн мэдүүлсэн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан “Төсвийн тусгай шаардлага”-д нийцсэн эсэх, 12.1, 12.3 дугаар зүйлд тусгагдсан “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд дараах үзүүлэлтийг тусгана”, мөн “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн агуулга”-тай нийцсэн эсэх, Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан төсөв боловсруулах шаардлагад нийцтэй эсэхэд анхаарсан болно.

ТТБЗ-өөс төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөлд дүгнэлт өгөхдөө баримталж ирсэн дараах гол чиглэлүүдийг харгалзан үзсэн. Үүнд:

- Төсвийн хууль эрх зүйн орчныг сайжруулах, бэхжүүлэх;
- Монгол Улсын төсвийн бодлого нь эдийн засгийн мөчлөг сөрсөн, макро эдийн засгийн зорилго, тогтвортой өсөлтийг дэмжсэн байх;
- Төсвийн тэлэлтийг багасган төсвийн тогтвортой байдлыг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх, ДНБ-д эзлэх төсвийн орлого, зарлага, өр төлбөрийн тэнцвэртэй байдлыг хангах, төсөвт тулгарч болзошгүй эрсдэлийг бууруулах;
- Төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын оновчтой байдлыг хангах, ДНБ-д эзлэх нийгмийн халамжийн зардлын хувь хэмжээг багасгах замаар төсвийн зарлагын бодлогыг сайжруулах зэрэг болно.

Засгийн газраас өргөн барьсан ДХТХМ-ийн төсөлд тус хуульд өөрчлөлт оруулах гол үндэслэлийг “Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг 33.4 их наяд төгрөг байхаар баталсан. Гэвч дэлхий дахинд бий болсон тодорхой бус байдал, түүнээс манай улсын эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийн улмаас 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл дэх төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлагын дүн хангагдахгүй байх эрсдэл үүсээд байна” хэмээн тодотгожээ (МУЗГ, 2025, хууд. 1). Түүнчлэн “Төсвийн бодлогын хувьд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засаг дахь төрийн оролцоог үе шаттай бууруулж, хувийн хэвшлийн бизнес тэлэх орон зайг нэмэгдүүлэх, эдийн засгийн салбаруудын бүтээмжийг дэмжих чиглэл баримтална. Эдгээр бодлогуудын хүрээнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026 онд ДНБ-ий 1.3 хувьтай тэнцэх дүнгээр алдагдалтай баталж хэрэгжүүлэх, цаашид 2027, 2028 онд төсвийн бодлогын орон зайг тогтвортой хадгалах болон нэмэгдүүлэх зорилгоор нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын дүнг үе шаттай бууруулахаар хуулийн төсөлд тусгав. Мөн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нэрлэсэн ДНБ-ий харьцаа 2023 онд 33 хувь, 2024 онд 37 хувь болж нэмэгдээд байсныг 2026 онд 30.9 хувь, 2027 онд 29.3 хувь, 2028 онд 28.2 хувь болгох


үе шаттай бууруулахаар хуулийн төсөлд тусгалаа” гэсэн нь энэ удаа өргөн барьсан төслийн гол үзэл санаа хэмээн үзлээ.

Нэг. Төсвийн бодлого, макро эдийн засгийн нөхцөл байдал

1.1 Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлагын хувь хэмжээг бууруулж байгаа нь бодлогын зөв сонголт гэж үзэж байна. 2018 онд төсвийн нийт зарлага ДНБ-ий 29 хувьтай тэнцэж байсан бол 2024 онд 38.3 хувь болж даруй 9.3 нэгжээр өссөн. Энэ нь эдийн засаг дахь төрийн оролцоог нэмэгдүүлж, хувийн хэвшлийн хөгжлийг хязгаарлах нөлөөтэйгөөс гадна цаашид төсвийн орлогоороо зарлагыг санхүүжүүлэх боломжгүй болох талаар ТТБЗ анхааруулсаар ирсэн. Засгийн газраас өргөн барьсан төсөлд үүнийг дунд хугацаанд 28.6 хувь болгож Ковид-19 цар тахлын өмнөх түвшинд хүргэхээр төлөвлөсөн нь ТТБЗ-ийн байр суурьтай нийцэж байна. Цаашид ДНБ-д эзлэх нийгмийн халамжийн зардлыг бууруулах чиглэлд анхаарах шаардлагатай байна.

1.2 Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах бодлогын чиглэл нь эдийн засгийн өсөлтийг дэмжих оновчтой түвшинд хараахан хүрэхгүй байна. Эдийн засаг дахь төрийн оролцооны оновчтой түвшин, хэлбэрийг тооцох нь идэвхтэй судалгааны сэдэв бөгөөд энэ хүрээнд эдийн засгийн өсөлтийг хамгийн их дэмжих төсвийн зарлагын хэмжээг тооцон гаргах боломжтой юм. Бид тус аргачлалаар Монгол Улс болон ДНБ-ий хэмжээ, бүтцээрээ түүнтэй ижил төстэй 26 орны 2000-2023 оны өгөгдөл дээр эконометрик шинжилгээ хийж үзэхэд “төсвийн зарлага ДНБ-ий 27% байх нь өсөлтөд хамгийн их эерэг нөлөөтэй” гэсэн үр дүнд хүрэв (Зураг 1). Өргөн мэдүүлсэн төсөлд төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь ирэх гурван жилд буурсаар 2028 онд 28.6% болохоор тусгасан нь дээрх критик утгаас өндөр байна.

Зураг 1. ДНБ-ий хэмжээ ижил төстэй 27 орны төсвийн зарлага болон эдийн засгийн өсөлтийн хамаарал, 2023 оны байдлаар



Албани, Азербайжан, Бангладеш, Болив, Чили, Гүрж, Гана, Гватемал, Гондурас, Киргизистан, Камбож, Молдави, Хойд Македон, Монгол, Малайз, Намиби, Никарагу, Пакистан, Перу, Филиппин, Паругвай, Риуанда, Сальвадор, Танзани, Уганда, Вьетнам

1.3 Эдийн засгийн таамаглал нь макро эдийн засгийн нөхцөл байдалд нийцтэй байна.

2025 оны хавар өргөн барьсан ДХТХМ-ийн төсөлд Засгийн газрын зүгээс 2025 оны эдийн засгийн өсөлтийг 7.5 хэмээн таамагласан нь бодит нөхцөл байдлаас хэт өндөр байсан гэж үзсэн тул ТТБЗ-өөс “Ойрын хугацааны таамаглал (Новкаст) хийхдээ 2025 оныг хэт өндөр төсөөлсөн байна” гэж дүгнэж байсан бол энэ удаад 2025 оны эдийн засгийн өсөлтийг 5.5 хувиар тооцсон нь харьцангуй хөрсөндөө буусан зөв хувилбар болсон гэж үзэж байна. Ингэснээр дунд хугацааны төсвийн бодлогын суурь бодитой болох боломж бүрдэнэ. Мөн 2026 оны эдийн засгийн өсөлтийн талаарх таамаглал нь ТТБЗ болон олон улсын байгууллагын таамаглалтай ойролцоо болсон байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны ТХМ-д тусгагдсан зарим үзүүлэлтийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	УИХ-аар 2025.05.30-нд баталсан 2026- 2028 оны ТХМ	ТТБЗ-ийн боловсруулсан таамаглал, 2025 оны 3-р сар	МУЗГ, Өргөн барьсан төсөл 2025 оны 9-р сар	ОУВС, Mongolia Article 4 mission statement, 2025 оны 6-р сар.
Эдийн засгийн өсөлт, хувь	6.0	5.4	5.7	5.5
Нэрлэсэн ДНБ /их наяд төг./	105.5	97.205-101.4	102.4	-
Инфляц, хувь	7.0	8.2	7.0	8.6
МУНТ-ийн тэнцвэржүүлсэн орлого /тэрбум төг./ (ДНБ-д эзлэх хувь)	33,479 (31.7%)	33,2-34,02 (35.77%)	31,600 (30.9%)	- (33.6%) ¹
МУНТ-ийн зарлага / тэрбум төг./ (ДНБ-д эзлэх хувь)	33,479 (31.7%)	34-35,02 (36.77%)	32,980 (32.2%)	(33%)
МУНТ-ийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төг./ (ДНБ-д эзлэх хувь)	0	[-1,014, -972.05] (-1%)	-1,380 (-1.3%)	-
Засгийн газрын өр / тэрбум төг./ (ДНБ-д эзлэх хувь)	52,750.0 (50%)	36,451-38,025 (37.5%)	51,200 (50%)	(46.8%)


1.4 Эдийн засгийн мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хэрвээ мөчлөг сөрсөн бодлогыг сүүлийн жилүүдэд, ялангуяа 2022-2024 онд тууштай хэрэгжүүлж чадсан бол төсвийн өнөөгийн нөхцөл байдал үүсэхгүй байсан. Энэ удаад Засгийн газрын өргөн барьсан төсөлд дунд хугацаанд баримтлах төсвийн бодлогын хүрээнд “Макро эдийн засгийг тогтворжуулахад мөчлөг сөрсөн төсвийн бодлого” баримтлах тухай дурдагдсан. Гэхдээ энэхүү бодлого нь зөвхөн эдийн засаг хүндэрсэн, төсвийн орлого тасалдсан, төсвийн зарлагыг тэлэх, хэвээр хадгалах, алдагдалтай төсөв батлах үед тод яригдаж, эдийн засаг өссөн, орлого нэмэгдсэн үед төсвийг тэлэхгүй байх, хуримтлал үүсгэх чиглэлд ашиглагдахгүй байгааг анхаарч мөчлөг сөрсөн бодлогыг тэлэх, агших мөчлөгт ялгаваргүйгээр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

¹ ОУВС төсвийн нийт орлогын ДНБ-д эзлэх хувийг тооцжээ.

1.5 Эдийн засгийн хувьд эрсдэл байсаар байгааг анхаарах шаардлагатай байна. 2025 оны эхний хагаст эдийн засгийн өсөлт 5.6 хувьтай гарсан ч энэ өсөлт оны эцэст хангагдах эсэх нь эргэлзээтэй байна. Учир нь энэхүү өсөлтийн дийлэнхийг мал аж ахуйн салбар бий болгосон бөгөөд намар ХАА-н салбарын энэхүү нөлөөлөл үргэлжлэхгүй төдийгүй газар тариалангийн салбарын эрсдэлтэй холбоотой буурах хандлагатай. Үүнээс гадна тээвэр, бөөний болон жижиглэнгийн худалдааны сааралт нь эдийн засгийн хувьд анхаарах асуудал юм.

1.6 Алдагдалгүй төсөв батлах үзэл баримтлалаас татгалзсан байна. 2025 оны төсвийн төслийн хэлэлцүүлгийн хүрээнд үүссэн асуудал нь олон нийт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхааралд хүрч, Ерөнхийлөгч бүхэлд нь хориг тавьснаар анх удаа алдагдалгүй төсөв батлагдсан нь цаасан дээр түүх болон үлдэхэд хүрч байна. Төсвийн эрх зүйн орчин шинэчлэгдэж Төсвийн тогтвортой байдлын тухай хууль батлагдсанаас хойш буюу 2010-2024 онд төсвийн тэнцэл 3 жилд (2010, 2018, 2023) нийт 855 тэрбум төгрөгийн ашигтай гарч байсан бол үлдсэн 12 жилд нийт 19.6 их наяд төгрөгийн алдагдалтай байсан (Зураг 2). Төсөв алдагдалтай хэрэгжиж ирсний нийгэм, эдийн засгийн үр дүнг тооцох шаардлагатай бөгөөд энэ тодорхойгүй байхад алдагдалгүй төсөв батлахад чиглэсэн бодлого ийнхүү өөрчлөгдөж байгааг эргэн харах нь зүйтэй юм.

Зураг 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцэл /2010-2024/



Эх сурвалж: (ҮСХ, 2025)

1.7 Хос алдагдлын мөчлөг дунд хугацаанд хадгалагдах эрсдэлтэй байна. 2023 онд Монгол Улс анх удаа төлбөрийн болон төсвийн тэнцлийн хувьд ашигтай гарсан нь эдийн засгийн хувьд ихээхэн эерэг үзүүлэлт болж чадсан. Энэ нь удаан хадгалагдаж чадаагүй бөгөөд 2024 онд тэнцлийн хос алдагдалтай гарсан. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, төлбөрийн тэнцлийн мэдээллээс харахад төсөв, төлбөрийн тэнцэл нь 2025 онд алдагдалтай гарахаар байгаа бөгөөд 2026 онд ч энэ байдал давтагдах эрсдэлтэй байна. Ингэснээр төсөв, урсгал тэнцлийн хос алдагдлын мөчлөгт эдийн засгийг оруулж болзошгүй юм. Энэ нь төлбөрийн тэнцэл, валютын нөөцөд сөргөөр нөлөөлж эдийн засгийн дархлааг сулруулах үр дагавартай гэдгийг дахин сануулж байна.

Хоёр. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Төсвийн тухай хуульд нийцсэн эсэх

2.1 Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Өргөн мэдүүлсэн төсөлд 2026 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 8,341.7 ам.доллар, нүүрсний

тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 133.7 ам.доллар байхаар төсөөлсөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.3-т заасан тодорхойлолтын дагуу тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон гэж үзэх үндэслэл болж байна.


2.2 Нэгдсэн төсвийн суурь тэнцэл ашигтай байх. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т “Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухай жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх” гэж заасан. Өргөн мэдүүлсэн төсөлд нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь 2026-2028 онуудад ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангасан байна.

2.3 Засгийн газрын өрийн нийт хэмжээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан. Өргөн мэдүүлсэн төсөлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2026-2028 онуудад хуульд заасан хязгаарт буюу 50 хувь, 45 хувь, 45 хувь байхаар тооцоолжээ.

2.4 Тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-т “2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна” гэж заасан. Өргөн мэдүүлсэн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2026-2028 онуудад ДНБ-ий -1.3, -0.8, -0.4 хувьтай тус тус тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангасан байна.

2.5 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн нэг удаагийн зохицуулалтад нийцэх. 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ болон нийт зарлагын дээд хэмжээг нэгэн зэрэг бууруулах өөрчлөлт орсонтой холбогдуулан жилийн төсөв, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлахад энэ хуулийн 7.5-д заасан хязгаарлалт хамаарахгүй” гэсэн 7.8 дахь заалт нэмсэн. Энэ заалтын дагуу 2026-2028 оны төсвийн орлого, зарлагын үзүүлэлтийг дараах байдалтай төлөвлөжээ.

Зураг 3. Дунд хугацааны ТХМ-д тусгагдсан төсвийн орлого, зарлагын харьцуулалт /2025.05.30, 2025.09.01/



Эх сурвалж: (МУЗГ, 2025)

Ингэснээр 2026 онд төсвийн орлогыг 1,879.5 тэрбум, зарлагыг 499.5 тэрбум төгрөгөөр бууруулж, 1,380.0 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөсөн байна. Энэ нь дээрх хуулийн зохицуулалтад нийцэж байна.

2.6 Олон нийтийн хэлэлцүүлэг. Төсвийн тухай хуулийн 28^{1.4}-т “Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь олон нийтийн хэлэлцүүлгийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн мэдүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн хугацаанд энэ зүйлд заасан журмаар зохион байгуулна” гэсэн заалтын дагуу хэлэлцүүлэг явуулсан үр дүнг төслийн танилцуулгад хавсралтаар тусгасан нь хуулийн заалтыг хэрэгжилтийг хангасан үндэслэл болж байна. Дунд хугацааны ТХМ нь төсвийн эрх зүйн орчин дахь гол бодлогын баримт бичиг болох тул түүнийг байнга өөрчилдөг өнөөгийн тогтолцоог халах тал дээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх шаардлага байгааг дурдах нь зүйтэй.

2.7 Төсвийн хүрээний мэдэгдлийн агуулга сайжирч байгаа ч төсвийн бодлогын үр нөлөөний асуудлыг анхаарах шаардлагатай байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.3-т “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь дараах агуулгатай” байна гэсэн заалт 12.3.4 болон 12.3.10 заалтуудын хувьд хэрэгжилт сайжирч байгаа боловч дараах заалтуудын хувьд анхаарах шаардлагатай хэвээр байна. Үүнд:

- 12.3.3.макро эдийн засгийн тогтвортой байдалд төсвийн бодлогын нөлөөллийн талаар хийсэн дүн шинжилгээ;
- 12.3.5.макро эдийн засгийн төлөв байдал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг тооцоход хэрэглэсэн аргачлал, тооцооны үндэслэл;
- 12.3.6.төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон нэгдсэн төсвийн тэнцэл, улсын хөрөнгө оруулалт, төсвийн нийт орлого, зарлагыг багтаасан төсвийн гол үзүүлэлтүүд, тэдгээрийн төлөвлөгөөг гүйцэтгэл, үр дүнтэй нь харьцуулсан байдал;
- 12.3.7.төсвийн болзошгүй өр төлбөр, түүний талаарх шинжилгээ;
- 12.3.8.өмнөх 2 жилийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөвлөлт, дараагийн жилийн болон түүний дараах дараалсан хоёр жилийн төлөв байдлыг хамруулан тооцсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө болон түүний гүйцэтгэл, төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт, төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт, түүний гүйцэтгэл, улсын өрийн нийт үлдэгдэл, авч ашиглах зээл, өрийн бичиг гаргалтын талаарх нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүд зэрэг заалтууд хамаарч байна.

Гурав. Ерөнхий дүгнэлт, зөвлөмж

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль (2010) батлагдсанаас хойш 21 удаа өөрчлөгдөж, энэ нь ТТБЗ орон тооны байнгын үйл ажиллагаатай болж бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлснээс хойш тухай бүр давтагдсаар байгаа талаар ТТБЗ анхааруулсаар ирсэн. Эдгээр өөрчлөлттэй холбоотой ДХТХМ нь төсвийг дагаж өөрчлөгддөг байсныг хязгаарлах хуулийн зохицуулалт 2025 оноос мөрдөгдөж эхэлсэн ч төсвийн бодлогын алдаа, гадаад эдийн засгийн орчны нөхцөл байдлаас шалтгаалан энэ жилийн ДХТХМ-д дахин өөрчлөлт оруулж

байна. Энэ байдлыг цаашид давтахгүй байх нь төсвийн тогтвортой байдал хадгалагдах, эрсдэл буурахад эергээр нөлөөлнө.

Үүнийг хэрэгжүүлэх гол үндэс нь үндэслэл бүхий сайн тооцоо, судалгаанаас гадна эдийн засгийн мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг тэлэлт, агшилтын мөчлөг ялгалгүйгээр хэрэгжүүлж, орлогын өсөлтийг дагаж зардлын хэт тэлэлтийг бий болгохгүйгээр хуримтлал үүсгэх, эдийн засаг хүндэрсэн үед зарлагыг хэт танахгүйгээр санхүүжүүлэх боломжтой байх явдал гэдгийг ТТБЗ-ийн зүгээс зөвлөж байна. Мөн хууль дээдлэх зарчмыг тууштай мөрдөх, Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай болон бусад хуулийн хэрэгжилтийг хангаж, хуулийг өөрчлөх бус, нийцүүлэх зарчмыг мөрдлөг болгох шаардлагатай байна.

Эцэст нь, ойрын хугацаанд төсвийн бодлого боловсруулахад бидний өмнө тулгамдаж буй зарим асуудалд анхаарал хандуулахыг хүсэж байна.

3.1. Хоёроос гурван жилийн дараа төсвийн тусгай шаардлагуудыг хангахад хүндрэл учрахаар байна. Өмнөх 5 жил буюу 2020-2024 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлын жилийн дундаж өсөлт 26.2% байсан бол нэрлэсэн ДНБ-ий өсөлт 17% байжээ (Хүснэгт 2). Энэ тренд цааш үргэлжилбэл гурван жилийн дотор буюу 2028 онд урсгал зардлын ДНБ-д эзлэх хувь 30%-аас хэтрэх буюу төсвийн тусгай шаардлага зөрчигдөх нөхцөл үүсэхээр байна².

Хүснэгт 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020-2024 оны урсгал зардлын өсөлт, түүний задаргаа

	2020	2021	2022	2023	2024
Урсгал зардлын өсөлт, хувиар	31.60	18.24	11.13	20.11	31.47
Цалин, хөлсний нөлөө	4.76	-1.08	-6.76	4.65	18.01
Бараа, үйлчилгээний бусад зардлын нөлөө	5.58	-0.30	-0.24	4.34	6.17
Зээлийн үйлчилгээний төлбөрийн нөлөө	0.95	-0.96	-0.30	2.48	0.14
Татаасны нөлөө	0.93	0.73	0.65	0.30	1.90
Урсгал шилжүүлгийн нөлөө	19.39	19.85	17.78	8.35	5.26

Засгийн газраас боловсруулан олон нийтийн санал авахаар 2025 оны 09 дүгээр 01-ний өдөр www.legalinfo.mn-д байршуулсан “Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд тусгагдсан шинэчлэлийн төсөвт үзүүлэх шууд нөлөө Сангийн яамны тооцоолсноор -4.0 их наяд төгрөг орчим байгаа нь ДНБ-ий 3-4% болох буюу мөн хэмжээний төсвийн алдагдал үүсгэн төсвийн тэнцлийн тусгай шаардлагууд 2027 оноос зөрчилдөхөөр байна.

3.2. Голлох эрдсийн бүтээгдэхүүний тэнцвэржүүлсэн үнийн төсөөлөл зах зээлийн нөхцөл байдлыг үл харгалзан өндөр байна. Нэгдсэн төсвийн 2026 оны ДХТХМ-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 2026 онд

² Урсгал зардлын жилийн өсөлтийг g , ДНБ-ийн жилийн өсөлтийг u гэвэл (Урсгал зардал/ДНБ) харьцааны өсөлт $r = \frac{g+1}{u+1} - 1 = 0.07$ болох ба өнөөдрийн байдлаар энэ харьцаа 0.25-0.27 байна гэвэл $0.25(1+r)^t = 0.3$ тэгшитгэлээс $t = 2.6$ жил.

133.7 ам.доллар байхаар, харин зах зээлийн үнийг 70 ам.доллар байхаар тооцжээ. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцохдоо Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.1.3.а-д заасны дагуу “... Олон улсын валютын сангаас гаргасан түүхий эдийн үнийн статистикт тусгасан тухайн төсвийн жилийн өмнөх дараалсан харгалзах 20, 19, 18 жилийн дундаж үнэ, эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг олон улсад нэр хүнд бүхий, Засгийн газраас тодорхойлсон санхүүгийн мэдээллийн байгууллагаас тухайн жилийн гуравдугаар сард анх зарласан өдрийн тухайн төсвийн жилийн болон түүний дараах гурван жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцох” мөн хуулийн 11.1.3.б-д заасны дагуу “... гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийн тооцоонд алтны тухайн төсвийн жилийн өмнөх дараалсан харгалзах жилүүдийн дундаж үнийг тусгахдаа эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг олон улсад нэр хүнд бүхий, Засгийн газраас тодорхойлсон санхүүгийн мэдээллийн байгууллагаас гаргасан статистикт тусгасан үнийн дунджаар тооцох” хуулийн зохицуулалттай байгаа нь зарим жилүүдэд гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ бодит үнээс хэт ялгаатай тогтох нөхцөлийг бүрдүүлж байна.

3.3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүд дутуу, буруу томъёололтой хэвээр байна. 2010-2025 оны хооронд Төсвийн тухай хуульд 71 удаа, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 21 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан нь эдгээр хуулиудын хоорондын уялдаа, нэгдмэл байдал болон зохицуулах чадварт нь сөргөөр нөлөөлж, төсвөө төсвийн хүрээ нь дагадаг, тодотгол хийн төсвийн орлого, зарлага буурсан үед ч хүрээ нь хөндөгддөг нөхцөлд хүрсэн байна. Иймээс эдгээр хуулиудын нийцлийг эргэн харж тодорхой өөрчлөлт оруулах шаардлага үүссэн байна. Тухайлбал, дараах гурван үзүүлэлтийг ДХТХМ-д тусгаж байх нь зүйтэй байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ордоггүй, төсвийн төлөвлөлт болон тусгай шаардлагуудад шууд хамааралтай үзүүлэлтүүд

ДХТХМ-д багтаагүй үзүүлэлтүүд	ДХТХМ-д багтаах үндэслэл
Нэрлэсэн ДНБ	Төсвийн тусгай шаардлагууд нэрлэсэн ДНБ-д эзлэх хувиар илэрхийлэгдэн хуульчлагдсан.
МУНТ-ийн урсгал зардал	Төсвийн тусгай шаардлагад туссан.
МУНТ-ийн орлого	Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, бодлогын бичиг баримтад тусгагддаг.

3.4. Дунд хугацааны ТХМ-д өөрчлөлт оруулах зохицуулалтыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд хангалттай тусгаагүй байна. Дунд хугацааны ТХМ-д өөрчлөлт оруулах тохиолдолд хуулийн төслийг өргөн барихдаа ТТБТХ-ийн 16¹.6 дахь заалт “Засгийн газар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг энэ хуулийн 16¹.5.1-д³ заасан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулаагүй бол түүний үндэслэл, шалтгааныг үзүүлэлт тус бүрээр бодлогын өөрчлөлтөөр тодорхойлж тайлбарлан, уг тайлбарыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн хамт өргөн мэдүүлнэ” гэсэн заалтыг баримтлах эсэх нь тодорхойгүй, нарийвчлан зохицуулалт тусгагдаагүй байна.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр

³ 16¹.5.1 дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал боловсруулах